

Төсөл

**“ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны.....дүгээр
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6, 46.8 дахь заалт, “Дулааны IV цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 14 дүгээр тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1.“Дулааны IV цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компани 2014 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлээр тайлант үед 4 595 049 252,54 /дөрвөн тэрбум таван зуун ерэн таван сая дөчин есөн мянга хоёр зуун тавин хоёр төгрөг тавин дөрвөн мөнгө/ төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ**

Эрчим хүчний яамыг
төлөөлж:

Төрийн өмчийн хороог
төлөөлж:

Сангийн яамыг
төлөөлж:

Д.ДЭЛГЭРЦОГТ

В.ДАРХАНБААТАР

М.БАТГЭРЭЛ

Төсөл

**“ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны.....дугаар
сарын -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус
гишүүдийг сонгож батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны саналыг үндэслэн “Дулааны IV цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Дулааны IV цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Т.Хишигт, Д.Содномдорж, Ч.Энхтуяа нарыг улираан сонгож баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд идэвхи санаачилгатай оролцож, ажиллахыг хараат бус гишүүдэд зөвлөсүгэй.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ**

Эрчим хүчний яамыг
төлөөлж:

Д.ДЭЛГЭРЦОГТ

Төрийн өмчийн хороог
төлөөлж:

В.ДАРХАНБААТАР

Сангийн яамыг
төлөөлж:

М.БАТГЭРЭЛ

**“ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 28 өдөр

№ 11

Улаанбаатар хот

2014 оны санхүүгийн тайлан тэнцлийн
дүнг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Дулааны IV цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6.10.10 дахь заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Дулааны IV цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт хөрөнгийг 436 675 882 367,07 /Дөрвөн зуун гучин зургаан тэрбум зургаан зуун далан таван сая найман зуун наян хоёр мянга гурван зуун жаран долоон төгрөг долоон мөнгө/ төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг /элэгдэл хассан дүн/ 395 981 513 132,31 /Гурван зуун ерэн таван тэрбум есөн зуун наян нэгэн сая таван зуун арван гурван мянга нэг зуун гучин хоёр төгрөг гучин нэгэн мөнгө/ төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг 40 694 369 234,76 /Дечин тэрбум зургаан зуун ерэн дөрвөн сая гурван зуун жаран есөн мянга хоёр зуун гучин дөрвөн төгрөг далан зургаан мөнгө/ төгрөгөөр, авлагыг 19 056 234 178,13 /Арван есөн тэрбум тавин зургаан сая хоёр зуун гучин дөрвөн мянга нэг зуун далан найман төгрөг арван гурван мөнгө/ төгрөгөөр, нийт өр төлбөрийг 116 485 764 319,02 /Нэг зуун арван зургаан тэрбум дөрвөн зуун наян таван сая долоон зуун жаран дөрвөн мянга гурван зуун арван есөн төгрөг хоёр мөнгө/ төгрөгөөр санхүүгийн тайлан тэнцлийн дүнг тус тус баталсугай.


2. Компанийн 2014 оны үйл ажиллагаанд дүгнэлт хийж, 2015 онд өртөг зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, санхүү төлбөрийн чадварыг сайжруулах, өр төлбөрийг барагдуулах, аудитын зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /П.Товуудорж/, Гүйцэтгэх захирал /Ж.Осгонбаатар/ нарт даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ**

Эрчим хүчний яамыг
төлөөлж:

Төрийн өмчийн хороог
төлөөлж:

Сангийн яамыг
төлөөлж:



Д.ДЭЛГЭРЦОГ



В.ДАРХАНБААТАР



М.БАТГЭРЭЛ

**“ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 сарын 28 өдөр

№ 2


Улаанбаатар хот


Ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6, 46.8 дахь заалт, “Дулааны IV цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 10 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Дулааны IV цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компани 2014 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлээр тайлант үед 4 595 049 252,54 /Дөрвөн тэрбум таван зуун ерэн таван сая дөчин есөн мянга хоёр зуун тавин хоёр төгрөг тавин дөрвөн мөнгө/ төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

Өрчим хүчний яамыг
төлөөлж:

Д. ДЭЛГЭРЦОГ

Төрийн өмчийн хороог
төлөөлж:

В. ДАРХАНБААТАР

Сангийн яамыг
төлөөлж:

М. БАТГЭРЭЛ

**“ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 сарын 28 өдөр

№ 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны
ажлын тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэхь заалтыг үндэслэн “Дулааны IV цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.10.12 дахь заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Дулааны IV цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны ажлын тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлыг тогтворжуулан, компанийн өмнө тавигдсан зорилтыг ханган биелүүлж, гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулан, дотоод хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулж, төлөөлөл хэрэгжүүлэгч гишүүдийн идэвх санаачилга, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тогтоосон хугацаанд хууль тогтоомжид заасны дагуу албажуулах, тайлагнах талаар анхаарч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /П.Товуудорж/-д даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ**

Эрчим хүчний яамыг
төлөөлж:



УХА0558
Д.ДЭЛГЭРЦОГ

Төрийн өмчийн хороог
төлөөлж:



В.ДАРХАНБААТАР

Сангийн яамыг
төлөөлж:



М.БАТГЭРЭЛ

**“ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 сарын 28 өдөр

№ 04

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны
зардлын төсөв батлах тухай**


Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “Дулааны IV цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.10.8 дахь заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Дулааны IV цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны зардлын төсвийг 45 530 400 /дөчин таван сая таван зуун гучин мянга дөрвөн зуу/ төгрөгөөр хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан төсвийн зарцуулалтанд хяналт тавьж, мөрдөн ажиллах, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг тэдний ажлын үр дүн, оролцоог харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /П.Товуудорж/-д үүрэг болгосугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ**

Эрчим хүчний яамыг
төлөөлж:


Д. ДЭЛГЭРЦОГТ

Төрийн өмчийн хороог
төлөөлж:


В. ДАРХАНБААТАР

Сангийн яамыг
төлөөлж:


М. БАТГЭРЭЛ

“ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4 сарын 28 өдөр

№ 05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 62 дүгээр зүйлийн 62.1.7 дахь заалт, “Дулааны
IV цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн
6.10.8 дахь хэсгийг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Дулааны IV цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн
удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр П.Товуудорж
/ЭХЯ-ны газрын дарга/, Г.Энхтайван /ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн/, Т.Батдондог
/ЭХЯ-ны хэлтсийн дарга/, Б.Энхтуул /ТӨХ-ны ахлах мэргэжилтэн/, Р.Мөнхтуяа /ТӨХ-
ны ахлах мэргэжилтэн/, М.Батгэрэл /СЯ-ны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтсийн дарга/, хараат бус гишүүнээр
Т.Хишигт /Мон энерги консалтинг ХХК-нд инженер/, Д.Содномдорж /НББ-ийг
хөгжүүлэх сангийн тэргүүн/, Ч.Энхтуяа /Си Эн Эм А ХХК-ийн захирал/ нарыг сонгож
баталсугай.

2. Компанийн өмнө тавигдсан зорилтыг ханган биелүүлэх, өр, авлагыг
барагдуулах, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд хуулийн дагуу
хяналт тавьж, идэвхи санаачилгатай ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдэд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

Эрчим хүчний яамыг
төлөөлж:

Д.ДЭЛГЭРЦОГТ

Төрийн өмчийн хороог
төлөөлж:

В.ДАРХАНБААТАР

Сангийн яамыг
төлөөлж:

М.БАТГЭРЭЛ

Төсөл

**“ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны.....дүгээр
сарын -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Компанийн 2014 оны санхүүгийн тайлан
тэнцлийн дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, “Дулааны IV цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Дулааны IV цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нийт хөрөнгийг 436 675 882 367,07 /дөрвөн зуун гучин зургаан тэрбум зургаан зуун далан таван сая найман зуун наян хоёр мянга гурван зуун жаран долоон төгрөг долоон мөнгө/ төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг /элэгдэл хассан дүн/ 395 981 513 132,31 /гурван зуун ерэн таван тэрбум есөн зуун наян нэгэн сая таван зуун арван гурван мянга нэг зуун гучин хоёр төгрөг гучин нэгэн мөнгө/ төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг 40 694 369 234,76 /дөчин тэрбум зургаан зуун ерэн дөрвөн сая гурван зуун жаран есөн мянга хоёр зуун гучин дөрвөн төгрөг далан зургаан мөнгө/ төгрөгөөр, эзэмшигчийн өмчийг 320 190 117 968,05 /гурван зуун хорин тэрбум нэг зуун ерэн сая нэг зуун арван долоон мянга есөн зуун жаран найман төгрөг таван мөнгө/ төгрөгөөр, нийт авлагыг 19 056 234 178,13 /арван есөн тэрбум тавин зургаан сая хоёр зуун гучин дөрвөн мянга нэг зуун далан найман төгрөг арван гурван мөнгө/ төгрөгөөр, нийт өр төлбөрийг 116 485 764 319,02 /нэг зуун арван зургаан тэрбум дөрвөн зуун наян таван сая долоон зуун жаран дөрвөн мянга гурван зуун арван есөн төгрөг хоёр мөнгө/ төгрөгөөр санхүүгийн тайлан тэнцлийн дүнг тус тус баталсугай.

2. Компанийн 2014 оны үйл ажиллагаанд дүгнэлт хийж, 2015 онд өртөг зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, санхүү төлбөрийн

чадварыг сайжруулах, өр төлбөрийг барагдуулах, аудитын зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга П.Товуудорж, Гүйцэтгэх захирал Ж.Осгонбаатар нарт даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

Эрчим хүчний яамыг
төлөөлж:

Д.ДЭЛГЭРЦОГТ

Төрийн өмчийн хороог
төлөөлж:

В.ДАРХАНБААТАР

Сангийн яамыг
төлөөлж:

М.БАТГЭРЭЛ